НАЙРСАГ ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ БЕЛАРУСЬ УЛС ХООРОНДЫН ГЭРЭЭГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ

2026 оны 10 дугаар
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 78 дугаар зүйлд заасны дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2026 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Тулга, Д.Энхтүвшин нар гэрээний төслийн орчуулгад анхаарах талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин Европын холбооны зүгээс Бүгд Найрамдах Беларусь Улсад тавьсан хоригтой холбоотойгоор орон нутгийн аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл өгсөн эсэх, хоёрдмол зориулалттай бараа бүтээгдэхүүний экспорттой холбоотой асуудлыг хэрхэн анхаарч ажиллаж байгаа талаар үг хэлсэн болно.

Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гэрээ соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ **Д.ЦОГТБААТАР**

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.~~Улаанбаатар хотноо~~ **Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хооронд** 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ”-г Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Гарын үсэг